

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

/Коронавируст ковид-19 цар тахлын халдварын үед Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн Онцгой байдлын газарт иргэд, ААНБ-аас хандивласан хандив тусламжийг шилэн дансанд мэдээлсэн эсэхэд хийсэн нийцлийн аудит/

АУДИТЫН КОД: АНГ-2021/125/-ШТА-НА

Аудитын 1 дүгээр хэлтэс

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер
Ц.Бат-Өлзий
Аудитор С.Лхагвасүрэн
Аудитор Д.Мөнхдэлгэр

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө
Г корпус 525 дугаар өрөө. Утас:11315578

Улаанбаатар хот
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Агуулга.....	2
Товчилсон үгийн жагсаалт	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилт.....	4
Аудитын хамарсан хүрээ.....	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн.....	5
Үндсэн мэдээлэл.....	5
1. 2020 онд Коронавируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой комисст цугларсан хандив, тусламжийн орлого түүний зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд хуульд заасны дагуу байршуулсан эсэх.....	6
2.2020 онд Коронавируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой байдлын газарт цугларсан хандив, тусламжийн орлого түүний зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд хуульд заасны дагуу байршуулсан эсэх.....	6
Аудитын дүгнэлт, зөвлөмж.....	7
Холбогдох байгууллагын санал.....	8

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НОбГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НОК	Нийслэл Онцгой комисс
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтыг үндэслэн, Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 06/1971 тоот албан бичгийг тус тус үндэслэн Нийслэл дэх Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Коронавируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Онцгой комисст 2020 онд цугларсан хандив, тусламжийн орлого түүний зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд хуульд заасны дагуу байршуулсан эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын хамрах хүрээ

Аудитаар Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Онцгой комисст 2020 оны 1 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хандивласан хандив, тусламжийн орлого, зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан эсэхийг хамруулав.

Үндсэн мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд хууль, журамд заасны дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, холбогдох мэдээллийг тодорхой хугацаанд мэдээлэх үүрэгтэй.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.1.¹, 2.2.1.12.²-т заасны дагуу хандив тусламжийн зарцуулалтын тайлангийн цэстэй байх бөгөөд журмын 3.2.7. “хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар” мэдээлэхээр тусгасан.

Мөн 2020 оны 8 дугаар сард Сангийн яамнаас НОК, НОБГ-т коронавируст халдвар (Ковид-19) цар тахалтай холбоотой мөнгөн болон мөнгөн бус хандив тусламжийн орлого, зарцуулалтыг иргэд олон нийтэд шилэн дансны цахим хуудсаар тогтмол мэдээлэх зорилгоор *“Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого зарцуулалтын мэдээ”, “Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого,*

¹ 2.1. Байгууллага бүр өөрийн цахим хуудсанд шилэн дансны цэстэй байх бөгөөд шилэн дансны цэс нь I) төсөв/гүйцэтгэл; II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; III) бусад; IV) Сангийн яамны мэдээлэл гэсэн дөрвөн дэд цэстэй байна

² 2.2.1.12 хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан

зарцуулалтын мэдээ” гэсэн 2 цэсийг нэмж хандив тусламжийн орлого, зарцуулалтыг мэдээлэхээр болжээ.

2020 онд иргэн, ААНБ-аас НОБГ-ын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд 229.4 сая, бэлэн мөнгөөр 15.0 сая, нийт 244.4 сая төгрөг, НОК-ын төрийн сан дахь дансанд 304.6 сая нийт 549.0 сая төгрөгийн мөнгөн хандив, 146.7 сая төгрөгийн бараа материал хандивлажээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан аудитыг гүйцэтгэлээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлан, анхан шатны баримт, дансны хуулгын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй харьцуулах, тулгах, мэдээлсэн эсэхийг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага уулзалт зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргана.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль дүрэм, журам зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Нийслэл дэх Төрийн Аудитын газрын аудитын нэгдүгээр хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ц.Бат-Өлзий удирдажаудитор С.Лхагвасүрэн, Д.Мөнхдэлгэр нар 2021 оны 9 дүгээр сарын 06-наас 9 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэв.

1. 2020 онд Коронавируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой комисст цугларсан хандив, тусламжийн орлого зарцуулалтын мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан уу?

НОК-ын төрийн сан дахь дансанд 2020 онд 13 удаагийн гүйлгээгээр 304.6 сая төгрөгийн орлого төвлөрч, 36 удаагийн гүйлгээгээр 250.8 сая төгрөгийг зарцуулан 53.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хандивын орлого болон зарцуулалтын нийт 49 гүйлгээ буюу 555.4 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны *“Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого зарцуулалтын мэдээ”* цэсэнд бүрэн байршуулсан.

НОК-т 2020 онд 41539 ширхэг буюу 146.7 сая төгрөгийн бараа материал хандивлажээ. Үүнээс 36789 ширхэг буюу 131.2 сая төгрөгийн орлого, 36539 ширхэг буюу 126.2 сая төгрөгийн зарцуулалтыг шилэн дансны цахим хуудасны *“Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ”* цэсэнд мэдээлсэн. Харин 4750 ширхэг буюу 15.5 сая төгрөгийн орлого, 5000 ширхэг буюу 20.5 сая төгрөгийн зарцуулалтыг дээрх цэсэнд байршуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 5.3³-т заасан *“Онцгой байдлын байгууллага нь ... хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг тухайн шатны Онцгой комисст ирүүлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. 2020 онд Коронавируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой байдлын газарт цугларсан хандив, тусламжийн орлого зарцуулалтын мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан уу?

НОБГ-ын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд 2020 онд 342 удаагийн гүйлгээгээр 244.4 сая төгрөгийн орлого, 4 удаагийн гүйлгээгээр 244.4 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс 340 гүйлгээ буюу 229.4 сая төгрөгийн орлого, 2 буюу 229.4 сая төгрөгийн зарцуулалтыг шилэн дансны цахим хуудасны *“Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого зарцуулалтын мэдээ”* цэсэнд мэдээлсэн. Харин 2 гүйлгээ буюу 15.0 сая төгрөгийн орлого, 2 гүйлгээ буюу 15.0 сая төгрөгийн зарцуулалтыг дээрх цэсэнд байршуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.4⁴, 25.7⁵, “Гамшгаас хамгаалах

³ Онцгой байдлын байгууллага болон энэ журмын 2.4-т заасан байгууллага нь хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг тухайн шатны Онцгой комисст ирүүлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна.

⁴ 6.3.4 төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

⁵ 25.7 Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана.

дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 2.3⁶, 2.4⁷, 5.3.⁸ заалтуудыг тус тус зөрчжээ.

НОБГ нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламж аваагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. 2020 онд Нийслэлийн Онцгой комиссын дансанд иргэд, ААНБ-аас мөнгөн хэлбэрээр хандивласан хандивийг бүрэн, харин мөнгөн бус материаллаг хандив, тусламжийн 87.8 хувийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.
2. Нийслэлийн Онцгой байдлын газарт иргэд, ААНБ-аас мөнгөөр хандивласан хандивын 93.8 хувийг мэдээлж 2 гүйлгээ буюу 15.0 сая төгрөгийн орлого, зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Нийслэлийн Онцгой байдлын газарт

Хандив тусламжийн орлого, зарцуулалтын мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж, бүртгэн тайлагнах, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах.

⁶ 2.3 Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ.

⁷ 2.4. Тодорхой байгууллагад нэр зааж ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг тухайн байгууллага хүлээн авч, бүртгэх, хадгалах ажлыг зохион байгуулах бөгөөд мөнгөн тусламжийг тухайн байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд бүртгэнэ.

⁸ 5.3 Онцгой байдлын байгууллага болон энэ журмын 2.4-т заасан байгууллага нь хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг тухайн шатны Онцгой комисст ирүүлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Үйлдвэрийн бүс-3, 4 дүгээр хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16030
Утас:(976-11) 31-83-89, (976-51) 26-45-72
<http://www.nobg.ub.gov.mn>

	2021.09.28	№	6/957	
тавтай	2021.09.27	-ны №	1040	-т

Н И Й С Л Э Л Д Э Х ТӨ Р И Й Н А У Д И Т Ы Н
Г А З Р Ы Н Д А Р Г А, Т Э Р ГҮҮ Л Э Х А У Д И Т О Р Ы Н
А Л Б А Н ҮҮ Р Г И Й Г ТҮ Р О Р Л О Н ГҮ Й Ц Э Т Г Э Г Ч
М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Тус газраас Коронаовируст цар тахлын үед Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Онцгой комисст 2020 онд цугларсан хандив, тусламжийн орлого, зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд хуульд заасны дагуу байршуулсан эсэхэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж саналгүй гэдгээ албан бичгээр хүргүүлж байна.



Нийслэлийн Онцгой Байдлын Газар
Удирдлага
Газрын Дарга, Хурандаа
Алтантуяа Дашням
2021.09.28 11:43